



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/64

Минцэлгэвч

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2 дах заалт, Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/36 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Баянжаргалан, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Өндөршил, Дэрэн, Гурвансайхан сумдад мал амьтны гоц халдварт шүлхий өвчин гарч өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан өвчилсөн мал амьтны устгал хийхэд шаардах нүх ухах хэрэгсэл дутагдалтай байгаа тул орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжигдэх "Аймгийн хэрэгцээнд эксковатор" нийлүүлэх ажлын шууд гэрээ байгуулахад хуулийн шаардлага хангасан гүйцэтгэгчийн үнийн санал авч шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Мөнхчулуун /Аймгийн Засаг даргын орлогч/

Гишүүд: О.Мөнхзул /АЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтэн/

Д.Ганбаатар / "Дундговь-Ус" ОНӨҮГ-ын дарга/

Хоёр. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.2-ын дагуу гүйцэтгэгч сонгох ажлыг зохион байгуулан ажлын хэсгийн дүгнэлтийг гаргахыг ажлын хэсэг /Ж.Мөнхчулуун/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0220192